UNITED NATIONS
INDUSTRIAL DEVELOPMENT ORGANIZATION

НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагын ЦАХИМ СУРГАЛТ

Сургалтын шинэ боломжийг дэлхийн олон оронд танилцуулж байна

АЖЛЫН БАЙРАНД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ

GOVERNMENT OF MONGOLIA

This project is funded by the European Union

Food and Agriculture Organization of the United Nations

UNITED NATIONS
INDUSTRIAL DEVELOPMENT ORGANIZATION

АЖЛЫН БАЙРАНД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ
цахим сургалтын танилцуулга

Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Аж үйлдвэр, хөгжлийн байгууллагаас Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" төслийн хүрээнд **“Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь”** цахим хичээлийн агуулгыг монгол хэлнээ хөрвүүлж, үндэсний хүмүүнлэгийн байгууллага Монголын Улаан Загалмай Нийгэмлэгтэй хамтран суралцагч танаа өргөн барьж байна. Сургалтын агуулгыг Австрийн Улаан Загалмайн Нийгэмлэг зөвлөж боловсруулсан юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага (НҮБАҮХБ /UNIDO) бол эдийн засгийн өсөлтийг хангаж, ядуурлыг бууруулахын тулд үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилготой Нэгдсэн Үндэстний Байгууллагын мэргэшсэн агентлаг юм. НҮБАҮХБ нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, байгаль орчин, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн технологийн асуудлаар дөч гаруй жил ажиллаж байна. НҮБАҮХБ нь арьс шир болон ноос ноолуур үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх чиглэлээр модульд суурилсан олон улсын сургалтуудыг боловсруулан хэрэгжүүлж буйгаас “Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь”, “Өндөрт ажиллах нь”, “Гутлын дизайн ба зохион бүтээлт”, “Арьс ширний ээлтэй үйлдвэрлэл” зэрэг модулиудыг монгол хэлнээ нутагшуулж, “Ноос ноолуур бэлтгэлийн чанарыг сайжруулах”, “Текстилийн гүйцэтгэн боловсруулалт” сэдэвт модулиудыг шинээр боловсруулан зорилтот бүлэгт хүргэх юм.

Сургалтанд хэн хамрагдах вэ?

- Үйлдвэрлэлийн бүх салбарт ажиллаж буй ажилчин, албан хаагч, менежерүүд
- Сонирхсон иргэд

Сургалтын товчоон

	Суралцах хугацаа:	20 цаг (60 минутаар)
	Үүнээс онлайн цаг:	8 цаг
	Хэрэгжүүлэгч:	МУЗН ба бусад
	Сэдэв:	Анхны тусламж үзүүлэх
	Түвшин:	Анхан шат
	Хэл:	Монгол хэлээр
	Видеоны тайлбар:	Монгол хэлээр



Сургалтын онцлог

- Ажлын байранд тохиолдож болох аюулгүй байдлын гол эрсдлүүд, ослоос урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийг **гутал, арьс шир боловсруулах үйлдвэрийн орчинд** онцлон авч үзсэн.
- Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх арга техник нь **үйлдвэрлэлийн аль ч салбар**ын ажлын байр төдийгүй **ахуйн нөхцөлд** ч ашиглах боломжтой.
- **Модульд суурилсан** учраас суралцагчдын ажлын байрны онцлог, хэрэгцээ шаардлагаас хамаарч дурын байдлаар сонгон хэрэглэж болно.
- **Интерактив, цахим** хичээлийг суралцагч **хүссэн цагтаа хүссэн газраасаа** Интернэтэд холбогдсон гар утас, таблет, суурин эсвэл зөөврийн компьютер ашиглан **өөрийн хурдаар** үзэж судална. Хичээлээ хэзээ ч сэргээн үзэх, насан туршдаа суралцах боломжтой.
- Товч тодорхой үзүүлэн слайд, гар зураг, видео, өөрийгөө сорих тестүүд нь суралцагчдыг **сонирхолтой, зугаатай** арга замаар сургалтын зорилгод хүргэнэ.
- Сургалтын материалыг онлайнаар бие даан суралцах төдийгүй **танхимын сургалтанд үзүүлэн хэрэгсэл** болгон ашиглахад тохиромжтой.
- Анхны тусламжийн сургалт нь мэргэжлийн багшаар удирдуулсан **дадлага ажил** шаарддаг тул цахим сургалтыг **танхимын сургалттай хослуулах** шаардлагатай. Онолын мэдлэгийг суралцагч цахим хэлбэрээр үзэж судалснаар **танхимын лекцийн цагийг багасгана**.
- Цахим ба танхимын дадлагажуулах сургалтыг **хүний их эмч**, МУЗН-ийн анхны тусламжийн **мастер сургагч багш нар** хөтөлж явуулна. Амжилттай төгсөгчдэд **Гэрчилгээ** олгоно.

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

1 Анхны тусламжийн хайрцаг

Ажлын байран дахь анхны тусламжийн хайрцагт зайлшгүй байх зүйлс, тэдгээрийг хэрхэн зөв хэрэглэх талаар мэдэж авна.

2 Зүрхний шигдээсийн үед анхны тусламж үзүүлэх

Гол шалтгаан, шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замуудыг таниулж, зүрхний шигдээсийн үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ.



3 Түлэгдэх үед анхны тусламж үзүүлэх

Ажлын байранд түлэгдэх осолд хүргэдэг аюулгүй байдлын гол эрсдлүүд, аюулгүй ажиллагааны арга хэмжээг таниулж, түлэгдэх ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүлнэ.

4 Химийн ослын үед анхны тусламж үзүүлэх

Ажлын байранд химийн бодистой холбоотой осолд хүргэдэг аюулгүй байдлын гол эрсдлүүд, аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийг таниулж, ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүлнэ.

5 Битүү бэртэх үед анхны тусламж үзүүлэх

Ажлын байранд битүү бэртэх осолд хүргэдэг аюулгүй байдлын гол эрсдлүүд, ослоос сэргийлэх аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг таниулж,
битүү бэртэж гэмтсэн үед анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүлнэ

6 Нүд гэмтэх үед анхны тусламж үзүүлэх

Ажлын байранд нүдэнд гэмтэл учруулж болзошгүй аюулгүй байдлын гол эрсдлүүд, ослоос сэргийлэх аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг таниулж,
нүд гэмтсэн үед анхны тусламж үзүүлэх зарчим, дараалал, арга хэмжээнүүдийг ойлгуулан ур чадвар олгоно.

7 Цус алдах үед анхны тусламж үзүүлэх

Ажлын байранд цус алдахад хүргэж болзошгүй аюулгүй байдлын эрсдлүүд, осол гэмтлээс сэргийлэх аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийн талаар ойлгуулж, цус ноцтой, их хэмжээгээр алдах үед анхны тусламжийг хэрхэн зөв, үр дүнтэй үзүүлэх талаар мэдлэг, ур чадвар олгоно.



8 Цахилгааны ослын үед анхны тусламж үзүүлэх

Ажлын байранд цахилгааны осолд хүргэдэг аюулгүй байдлын гол эрсдлүүд, ослоос урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны арга хэмжээнүүдийг таниулж, ослын үед анхны тусламж үзүүлэх мэдлэг ойлголт, ур чадвар эзэмшүүлнэ.



АЖЛЫН БАЙРАНД АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ

Анхны тусламж гэдэг нь аливаа өвчлөл, биеийн хямрал, осол гэмтлийн үед эмнэлгийн тусламж ирэхээс өмнө цаг алдалгүй, гарын доорх материал, боломжийг ашиглан өөртөө болон бусдад үзүүлэх тусламжийг хэлнэ. Анхны тусламж үзүүлэх мэдлэгтэй байх нь зөвхөн танд төдийгүй таны гэр бүл, найз нөхөд, хамт ажиллагчид, цаашлаад нийгэмд ихээхэн ач тустай юм.

> Гэнэтийн ослын үед амь аврагдсан хүмүүсийн 90 хувьд нь жирийн иргэд анхны тусламж үзүүлсэн байдаг.

Хэлэхэд билэггүй боловч хичнээн сэргийлсэн байлаа ч осол аваараас зугатаж зайлсхийх боломжгүй агшин амьдралд тохиолддог нь үнэн билээ. Таны гэрт, ажлын байранд, олон нийтийн газарт гэнэтийн осол болоход харсаар байж бусдад тусалж чадахгүй байх нь ихээхэн гэмшил дагуулдаг. Ийм учраас аль болох олон хүнийг анхны тусламж үзүүлэх мэдлэг чадвартай болгох нь аливаа нийгмийн аюулгүй, баталгаат амьдралын нэг үндэс болдог. Анхны тусламж үзүүлэх арга техник бол харьцангуй энгийн юм. Гагцхүү түүнийг мэдэх, зөв дэс дарааллаар гүйцэтгэх нь чухал байдаг.

АНХНЫ ТУСЛАМЖИЙН СУРГАЛТ ЯАГААД ЧУХАЛ ГЭЖ?

- **Аюулгүй ажиллагааг сайжруулна.**
  Анхны тусламжийн сургалтын гол суурь нь ослоос урьдчилан сэргийлэх дадал зуршлын тухай юм. Аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж, сонор сэрэмжтэй байх нь осол гэмтэлгүй ажиллаж, амьдрах үндэс билээ.
- **Хүний амь насыг аварна.**
  Гэнэтийн осол, өвчлөлийн үед анхны тусламжийн мэдлэгтэй хүн бол осолдогчид зөв тусламжийг өөртөө болон бусдад аюулгүйгээр, итгэлтэйгээр, цаг хором алдалгүй үзүүлж, амь насыг нь аварна.
- **Өвдөлтийг намдаана.**
  Зарим төрлийн осол гэмтлээс үүссэн хүчтэй өвдөлтийг анхны тусламжийн мэдлэгтэй хүн бол энгийн арга техник ашиглан, эмнэлгийн тусламж иртэл хэсэг зуур ч болов намдаана.
- **Хүмүүсийг амгалан тайван байлгана.**
  Шаардлага тулгарвал өөрийн болон бусдын амь насыг аварч чадах мэдлэг, итгэл үнэмшил нь таныг болон таны эргэн тойрны хүмүүсийг ослын үед амар тайван байхад тусална. Анхны тусламжийн мэдлэгтэй хүн шокийн үед сандарч тэвдэлгүй хэрхэхийг мэддэг. Тэд зөвхөн эмнэлгийн тусламж үзүүлээд зогсохгүй түүний өөртөө итгэлтэй байдал нь осолдогчид сэтгэл санааны ихээхэн дэмжлэг болно.
- **Эдгэрэлтийг түргэсгэнэ.**
  Анхны тусламжийн мэдлэгтэй хүн нөхцөл байдлыг дордуулахгүйгээр осол гэмтлээс шалтгаалсан хүндрэлээс сэргийлж чадна. Энэ нь осолдогчийн идэвхтэй амьдралыг эрт сэргээхэд нэн тустай.

https://www.capacitydevelopment.unido.org/moodle/

НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллагаас гаргасан “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь” сэдэвт цахим хичээлд хэрхэн элсэх вэ?

1 Интернэтэд холбогдсон компьютер, нөүтбүүк, таблет, ухаалаг гар утасныхаа вэб хөтөч дээр **https://capacitydevelopment.unido.org/moodle/** хаягаар орж, шинэ хэрэглэгч үүсгэх **Create new account** холбоосыг дарна



* Та ухаалаг гар утасныхаа Playstore, эсвэл App Store-т Moodle гэж бичээд хайлт хийн дараах апп-ыг татаж суулгаад ашиглаж болно.



2 Бүртгэлийн маягтыг бүрэн бөглөж, холбогдох нэр, нууц үг, имэйл хаягаа оруулаад **Create my new account** товчийг дарна:



Бүртгэлийг баталгаажуулах хуудас гарч ирнэ:



3

Имэйлээ шалгаж, **баталгаажуулах холбоос**ыг дарах буюу эсвэл хуулж аваад вэб хөтчийн хаягийн мөрөнд оруулна:



Сургалтын талбарт нэвтэрсэн байх ба **Courses** товч дарна:



* Ийнхүү та талбарт бүртгэлтэй хэрэглэгч болж байгаа ба дараагийн удаа нэвтрэхдээ нүүр хуудсанд зөвхөн хэрэглэгчийн нэр, нууц үгээ оруулна.



4 Талбарын баруун дээд булан дахь **Expand all** холбоосыг дарж, гарч ирэх орнуудын жагсаалтаас **Монгол улс**ыг сонгоно:



“Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь” хичээлийн нэр дээр дарна:



5 Хичээлд бүртгүүлэхийн тулд **Enroll me** товчлуурыг дарна:



6 Хичээлийн талбар дахь **суралцахуйн үйл ажиллагаа**нуудыг хийж гүйцэтгэнэ.
Үүнд: онлайн хичээлийн агуулгыг судалж, хэлэлцүүлэгт оролцон, даалгавар хийнэ:



7 Талбараас гарах бүрдээ баруун дээд булан дахь жижиг сумыг дарж,
Log out товчийг дарж гарахаа мартуузай.

ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ОСОЛ ГЭМТЛИЙН СТАТИСТИК

Монгол Улсын Эмнэлгийн тусламж үйлчилгээний зохион байгуулалтын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 10, 11-р зүйлд зааснаар **эмнэлгийн яаралтай түргэн тусламжийг мэргэжлийн эмнэлэг, эмнэлгийн ажилчид болон тухайн чиглэлээр сургагдсан анхан шатны мэдлэг чадвартай хүн үзүүлж болно; бүх аж ахуй нэгж байгууллагууд анхны тусламжийн нэгж/хайрцагтай байх шаардлагатай** гэж заасан байдаг.

“**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр**”-т 10,000 хүн тутамд ногдох үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртөгсдийн тоог 2020 гэхэд 3, нас барагсдын тоог 0.3 болгож бууруулах зорилт тавьсан. Гэвч энэ үзүүлэлт 2018 оны байдлаар уул уурхай, олборлолтын салбарт 12.1; ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт 13.0 байгаа нь онц анхаарал татаж байна:



Осол гэмтлийн шалтгааныг авч үзвэл өндрөөс унах, бохир усны цооногт унах, цахилгаан гүйдэлд цохиулах, халтирах, эргэлтэт тоног төхөөрөмжийн хаалт хамгаалалтыг хийгээгүйгээс гэмтэж бэртэх ослууд давамгайлж байна.

Ажлын байранд анхны тусламжийг цаг тухайд нь зөв үзүүлснээр **эдгэрэлтийг хугацааг 30%-иар хурдасгадаг** бөгөөд энэ нь мөн ажилтны эдийн засгийн байдалд сайнаар нөлөөдөг. Хүн бүр анхны тусламж үзүүлэх чадвартай болсноор цаашид өөрийнхөө болон бусдын амь насыг аврах чадвартай болох юм.

Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 хэлэлцүүлгээр **иргэн бүрийг анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулах** зорилт тавьж ажиллах талаар төрийн болон төрийн бус байгууллагуудын удирдлагууд хэлэлцэж, **Монгол хүний дундаж наслалтыг 78 хүргэх** зорилт тавьж ажиллахаар болсон билээ.

СУРГАЛТЫН ТҮНШ БАЙГУУЛЛАГА

МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГ

(1939 оноос хойш)

Монголын Улаан Загалмай Нийгэмлэг бол 1939 онд байгуулагдсан, үндэсний хэмжээний, тэргүүлэх хүмүүнлэгийн байгууллага юм. МУЗН нь Хүн амын эрүүл мэндийг дэмжих, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад туслах, гамшгийн эрсдлийг давах туулах чадварыг нэмэгдүүлэх, нэрвэгсдэд анхны яаралтай тусламж үзүүлэх, нийгмийн эмзэг бүлгийн амьдралын чанарыг сайжруулах, хүүхэд залуучуудын дунд хүмүүнлэгийн хөдөлгөөнийг өрнүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг Гамшгийн менежмент, Эрүүл мэнд, халамж, Хүүхэд залуучуудийн хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд хүрч ажиллаж байна.

Анхны тусламжийн сургалт нь МУЗН-ийн үндсэн үйл ажиллагаа бөгөөд 1995 оноос Анхны тусламжийн сургагч багш бэлтгэн, жолооны дамжаа, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалт явуулж эхэлсэн. 2015 оноос эхлэн уул уурхай, спортын клуб, аялал жуучлалын компани, үйлдвэр аж ахуйн нэгжүүдэд анхны тусламжийн сургалтыг тогтмол явуулж байна.

НҮБАҮХБ-ын “Ажлын байранд анхны тусламж үзүүлэх нь” танхимын ба цахим хосолсон сургалтыг нэвтрүүлснээрээ суралцагчдад онолын мэдлэгийг цахимаар хүссэн цагтаа, хүссэн газраасаа үзэж судлах боломжийг олгож буй давуу талтай юм. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл нь уг холимог сургалтыг нэвтрүүлэхэд МУЗН-тэй хамтран ажиллаж, цахим сургалтын талбар, сургалтын агуулга, арга зүйгээр ханган ажиллаж байна.

Ажлын байранд анхны тусламж үзүүлэх мэдлэг, ур чадвар олж авснаар та осол гэмтлийн үед бусдын амь насыг аврах, насан туршийн гэмтэл согогтой болохоос нь хамгаалж чадна.

МОНГОЛЫН
УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГ

Сүхбаатар дүүрэг, Энхтайваны гудамж
МУЗН-ийн төв байр
+976 11 323334
info@redcross.mn
https://www.redcross.mn/

“МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ” ТӨСӨЛ

Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө,
Засгийн газрын 9б байр, 23 тоот
+976 7018-0180
leather@unido.org
https://www.capacitydevelopment.unido.org/moodle/